



Орхон аймгийн ЗДТГазар

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
2014 ОНЫ 9-Р САРЫН 29-  
НИЙ ӨДӨР ӨГСӨН ШУУРХАЙ  
ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮҮРЭГ  
ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2014 оны 10 сарын 13-ны өдөр

**1.Орон сууцнуудын  
халаалтыг жигдрүүлэх,  
халаалтыг стандарт  
хэмжээнд барих :**

- **Биелэлт:** Орон сууцны халаалтыг жигдрүүлэх тал дээр ажилллаж байна. Өнгөрсөн 7 хоногт Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах төв дээр халаалттай холбоотой 20 гомдол санал ирсэн байна. Үүнд: 2-р хорооллын 23, 26, 27, 28, 34, 1-р хорооллын 1-р байр, 5-р хорооллын 12, 15, 18 дугаар байр, 4-р хорооллын 5, 7-р хороолол, Тамирын 3 чулуу, Говилын 100 айлын оршин суугчдаас ирүүлсэн байна. 2-28-р байр болон 2-34-р байрны халаалтын шугамын гэмтэлүүдээс шалтгаалан зарим айл өрхийн халаалт доголдож байгаа бөгөөд гэмтэлийг засварлаж байна.

**2. Улсын комисс хүлээн  
авсан гэр хорооллын  
гэрэлтүүлгийг бүрэн  
асаах :**

- **Биелэлт:** Уртын гол багийн гэрэлтүүлэгээс бусад гэрэлтүүлгийг бүрэн асаасан бөгөөд тус багийн гэрэлтүүлгийг "Эрдэнэт Булганы ЦТС" ТӨХК-нд мэдэгдэж асаах талаар үүрэг чиглэл өгч ажилласан байна.

**3.Өвөлжилтийн  
бэлтгэл ажлын явцыг  
хянан, бэлтгэлийг  
бүрэн хангуулах :**

- Ургац хураалтын мэдээг 7 хоног бүр шинэчилэн гаргаж ҮХААГ-т хүргүүлж байгаа бөгөөд 10 сарын 09-ны байдлаар нийт 4689,53 га-д тариалалт хийсэнээс **4106 га –аас 13932,2 тн ургац хураан авч гүйцэтгэл 88%-тай** байгаа бөгөөд **3720** га-д үр тариа тариалснаас 3225 га-аас 8114,2 тн буюу га-аас 25,2 цн авч гүйцэтгэл 87,4 %-тай байна. Төмсний 97%, хүнсний ногооны 90,% тэжээлийн ургамлын 95 % тосны ургамал 100 % тус тус хураагаад байна
- Энэ жил 9500 тн хадлан бэлтгэхээс 10 сарын 08-ны байдлаар нийт 9815.0 тн бэлтгэж 103.3 хувьтай байна. Аймаг, сумын аюулгүй нөөцөд байгалийн хадлан 192 тн, тэжээл 60 тн-ыг бэлтгэв.

- Инженерийн шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах тухай аймгийн Засаг даргын А/518 дугаартай захирамжыг гарган ажиллаж байна. Уг захирамжинд 8 засварын ажил тусгагдсан бөгөөд Говил багийн 31, 34-р байрны гадна ИШС –ний засварын ажил хийгдэж, энэ 7 хоногт дуусгахаар ажиллаж байна.
- Баян-Өндөр сум: Баян-Өндөр сумын өвөлжилтийн бэлтгэл ажил 90,0 хувьтай байна.
- Жаргалант сум : Сумын өвөлжилтийн бэлтгэл ажил 92,3 хувьтай байна.



# Анхаарал тавьсанд баярлалаа



2014 оны 10-р сарын 13